



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/289
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Үйлдвэр урлалын политехник коллежийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.



**ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛ ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖИЙН ТӨСВИЙН 2016 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Аудитын тайлан

Үндэсний аудитын газар:

1. САГ-ын дарга, Тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас:

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

2. Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

“Нью Эстимэйтор Аудит” ХХК:

1. Захирал Ж.Үхэрбат
Утас: 99117097

2. Ахлах аудитор Д.Баяраа
Утас: 99359981

Хаяг: УБ хот ЧД, Ж.Самбуу-22
“Зоос гоёл” №213

2017 оны 02 дугаар сарын 21

АГУУЛГА:

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/93 тушаалаар батлагдсан 47/2016 тоот “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ”-ний дагуу Үйлдвэрлэл урлал политехник коллежийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Үйлдвэрлэл урлал политехник коллежийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Үйлдвэрлэл урлал политехник коллежийн төсвийн 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудитыг 2016 оны 10 дугаар сараас эхэлж, жилийн эцсийн санхүүгийн тайланд 2017 оны 01 дүгээр сарын 27-ноос 02 дугаар сарын 21-ний хооронд хийхээр төлөвлөн компанийн захирал Ж.Үхэртар, ахлах аудитор Д.Баяраа, аудитор Ү.Алтанзул нар гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-А-9/

Үйлдвэрлэл урлал политехник коллеж нь төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 1дүгээр сарын 24-ний өдрийн 2/28 тоот албан бичгээр “Нью Эстимэйтор Аудит” ХХК-д ирүүлсэн.

“Нью Эстимэйтор Аудит” ХХК нь аудитыг Төсвийн тухай хууль болон аудитыг хийх төлөвлөгөө, хөтөлбөрт заасан хугацаанд тус тус багтаан Үндэсний аудитын газраар хянуулж, аудитын тайланг Үйлдвэрлэл урлал политехник коллежийн удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Үйлдвэрлэл урлал политехник коллежийн төсвийн захирагч нь Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсролын тухай хууль, бусад хууль, Засгийн газрын тогтоол, салбарын Сайдын гаргасан тушаал шийдвэр болон бусад нийтлэг заавар, журмыг мөрдөж үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Тус сургууль нь зорилгоо “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчдын шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх” гэж тодорхойлсон байна.

Байгууллагын бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “төсвийн байгууллагань түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасан байна.

Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн 2016 оны төсвийн санхүүжилтийг Хөдөлмөр Нийгмийн хамгаалалын яамнаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрхзүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой төсвийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн үйл ажиллагааны талаар/ТАБ-СТА-А-1/маягтад тодорхой тусгасан.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль, тогтоол, заавар, журмыг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Үйлдвэрлэл урлал политехник коллежийн төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 11-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Үйлдвэрлэл урлал политехник коллежийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/218 дугаар тушаалаар Хөдөлмөрийн салбарын хэмжээнд мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг баталж мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4 дүгээр бүлгийн Бараа, материалын бүртгэлийн Нэг заалтыг эс тооцвол УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

Үйлдвэрлэл урлал политехник коллежийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн

технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Үйлдвэрлэл урлал политехник коллежийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

5. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Үйлдвэрлэл урлал политехник коллежийн төсвийн шууд захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал зардлыг санхүүжүүлэхээр 1,738.2сая төгрөгийг баталснаас гүйцэтгэлээр 1,736.6 сая төгрөгийг олгосон нь 1,6 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

Мөн Сайдын багцаас 120,0 сая төгрөг, Мэргэжлийн боловсролыг дэмжих сангаас суралцагчдын тэтгэлэгт 63,5 сая төгрөг, Мэргэжлийн боловсролын салбарын чуулга уулзалтанд оролцогсдын хоолны зардалд 2,2сая төгрөг, 2015 оны татан төвлөрүүлтээс буцаан авсан авлага 1,8 сая төгрөг нийт 187,5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт /орлого/-ыг авсан байна. Үндсэн үйл ажиллагааны орлогод 310,0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогод 92.0 сая төгрөгийн орлого нийт 402,0 сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталсанаас Үндсэн үйл ажиллагааны орлогын хувьд гүйцэтгэлээр 329,1 сая төгрөгийг, туслах үйл ажиллагааны орлогод 47,7 сая төгрөг нийт 376,8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн зарцуулсан байна. Актлагдсан үндсэн хөрөнгө борлуулж 1,4 сая төгрөгийн мөнгөн орлого олсон байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар урсгал зардалд 2,140.3сая төгрөг батлагдсанаас урсгал зардалд 2,095.9 сая төгрөг, хөрөнгийн зардалд 16,7 сая төгрөгийг тус тус зарцуулж, батлагдсан төсвийг 27,5сая төгрөгөөр хэмнэсэн гэж тайлагнагдсан байна.

Харин мөнгөн бус орлогын хувьд а) цалингийн суутгалаархи орлогоор 3,5 сая төгрөг, б) Гадаадын зээл тусламжаар 1,708.2сая төгрөгийн үндсэн хөрөнгө болон бараа хүлээн авч орлогоор тооцож тус тусын холбогдох дансанд бүртгэж санхүүгийн тайланд тайлагнасан байна.

7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу бүх мэдээллийг оруулсан байна. Тус мэдээллийг <http://www.shilendans.gov.mn/org/1499> холбоосоор мэдээлэл авахыг хүссэн этгээд авч болно. Үүнд төсвийн гүйцэтгэлийн мэдээг 1-12 сараар өссөн дүнгээр, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын мэдээг 1-12 сараар тус тус гаргасан байна.

8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 35 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Урсгал зардалд батлагдсан төсвөөс үндсэн хөрөнгө бэлтгэсэн, зарим зардлын төлөвлөлтийн үндэслэл хангалтгүй, ТГТ, МГТ-ууд хоорондоо зөрүүтэй тайлагнагдсан, кассын анхан шатны зарим баримтын бүрдүүлэлт дутуу зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр эрсдлүүд нь хөрөнгийн захиран зарцуулалтын эрхийг хэтрүүлэх, төсвийг хяналтгүй зарцуулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

9. Материаллаг байдлын түвшинг сонгосон үндэслэл:

Материаллаг түвшний хувьд нийт орлого, нийт болон цэвэр хөрөнгийн дүн нь тус тус өндөр гарч байгаа тул бага дүнтэй нийт зардлаас материаллаг байдлын түвшинг тогтоох нь зохимжтой гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үе шатанд тооцсон нийт зардлын 1%-иарбуюу 34,8 сая төгрөг байхаар тогтоов.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Үйлдвэрлэл урлал политехник коллежийн төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, санхүүжилт, нэмэлт санхүүжилт, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого, түрээсийн тооцоо, торгууль, шимтгэлийн орлого, өглөг, авлагын тооцоо, тогтмол зардлын тооцоо, ХАОАТ, НДШ-ийн тооцоо үлдэгдэл, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, хоолны тооцоо, нормын хувцас зөөлөн эдлэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, 1 удаагийн тэтгэлэг, нэмэгдэл, сургалт семинар, хичээл дадлагын зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

/ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт санхүүжилт, орлогын 99,9 хувь, мөнгөн хөрөнгийн 53 хувь, нийт зардлын 35,3 хувь /2015 оны санхүүгийн аудитаар цалингийн зардалд нарийвчилсан горим гүйцэтгэсэн тул энэ аудитад хийгдээгүй/, нийт хөрөнгийн 100 хувь, нийт өр төлбөрийн 100 хувийг тус тус эзэлж байна.

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/218 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөрийн салбарын "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4 дүгээр бүлгийн 4.3 дахь Бараа, материалын бүртгэлийн 4.3.4-т "Нэг жилээс илүү 3 жилээс бага ашиглалтын

хугацаатай хөрөнгийг Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс хэмээн хүлээн зөвшөөрч бараа материалын дансны бүлэгт Хангамжийн материал гэсэн хэсэгт бүртгэж болно" -гэж заасан нь дараах стандарт, заавар, журмыг зөрчсөн байна. Үүнд:

- Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт /УСНББОУС 17/ "Үндсэн хөрөнгө"-ийн 17.3-т "Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм"-гэж заасан байна.
- Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын НББ-ийн дансны заавар"-ын 4.29-д "Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнэ, элэгдэл шимтгэлийн хэмжээг тодорхойлох, дахин үнэлгээ зэрэг НББ-ийг УСНББОУС17 "Үндсэн хөрөнгө"-ийг дагаж мөрдөнө"-гэж
- Мөн тушаалын 4.15-д "Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө."- гэсэн;
- УСНББОУС 12 "Бараа, материал"-ын 12-т Улсын секторын бараа материалд дараах зүйлс багтана- гэсний дагуу 12(г)-д " Үндсэн Хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн стандартад авч үзсэнээс бусад барилга байгууламж болон тоног төхөөрөмжид ашиглах зорилготой нөөц, сэлбэг" гэж хүлээн зөвшөөрөхөөр заасан байна.

Иймд Хөдөлмөрийн салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4 дүгээр бүлгийн 4.3 дахь Бараа, материалын бүртгэлийн 4.3.4 дахь заалтыг эргэн харах, залруулах шаардлагатай байна. /салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа болно./

Шийдвэрлэсэн:БайгууллагадХөдөлмөр, нийгмийн хамгаалалын яаманд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг УСНББОУС болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журамтай нийцүүлж өгөх талаар асуудлыг тавьж шийдвэрлүүлэх зөвлөмжийг өгөх

2.Батлагдсан төсөвт зардлаас хичээл, дадлагатай холбогдуулан 6,0 сая төгрөгийн ном, оёдлын машин гэсэн үндсэн хөрөнгийг худалдан авсан нь дараахь хууль, журмыг зөрчсөн байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"-гэсэн;
- Сангийн сайдын баталсан 2013 оны 73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн журам"-ын 8 дугаар зүйлийн 8.1-д "Төсвийн байгууллага нь олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулахаас өөр бусад хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно."-гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:Урсгал зардалд батлагдсан төсвөөс үндсэнхөрөнгө бэлтгэхгүй байх. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахталаартус тус зөвлөмж өгөх.

3. Тус байгууллагын 2016 оны төсөвт өөрийн орлогын эх үүсвэрийг: 1) үндсэн үйл ажиллагааны орлого болох суралцагчдаас авах мэргэшүүлэх сургалтын төлбөрт 310,0 сая төгрөгөөр, 2) туслах үйл ажиллагааны орлогод цайны газар, ТҮЦ-ийн түрээс 5,6 сая төгрөг, дотуур байрны төлбөрт 70,0 сая төгрөг, БАЗТ-ийн орлого 16,4 сая төгрөг нийт 92,0 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлэн зарцуулахаар баталсан байна.

Аудитаар үндсэн болон туслах орлогын гүйлгээг тулган шалгахад:

-Үндсэн үйл ажиллагааны орлого 329,1 сая төвлөрүүлсэн нь батлагдсан төсвөөс 19,0 сая төгрөг буюу 6%-иар илүү төвлөрүүлсэн байна.

-Туслах үйл ажиллагааны орлогын хувьд нийт 92,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 47,7 сая төгрөгийг төвлөрүүлж гүйцэтгэл 52%-тай байна. Тухайлбал:

1. Бүсийн арга зүйн төлбөрийн орлого /багшлах эрхийн төлбөр/-ыг 16,4 сая төгрөгөөр баталсан. Гүйцэтгэлээр 30,2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2. Дотуур байрны төлбөрийн орлого 70,0 сая төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 14,6 сая төгрөг болж 55,4 сая төгрөг буюу 79,1 %-иар дутуу төвлөрүүлсэн байна.

Дотуур байрны төлбөр дутуу төвлөрүүлсэн шалтгааны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 01 дугаар сарын 20-ны өдрийн 8/190 тоот албан бичигт суралцагчийн дотуур байрны төлбөрийг авахгүй байх тухай заасан албан бичгийг ирүүлсэн тул төлбөрийг зогсоосон байна.

Мөн дотуур байрны суралцагчдаас төлбөр авч байгаа нь дараахь хуулийн заалтуудтай нийцэхгүй байна.

- Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т "Төрийн өмчит ... мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны нийт зардал ... улсын төсвөөс санхүүжүүлнэ." –гэсэн;
- Хуулийн 43.2.2-т"ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байранд төлбөргүй суух."-гэсэн;.

Шийдвэрлэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яаманд төсвийн төлөвлөлт, батлуулахтай холбоотой асуудлыг тавьж шийдвэрлүүлэх зөвлөмжийг өгөх

12. Анхаарал татахуйц бүсэд чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар ажиллагсадын цалин, нийгмийн даатгал, татвартай холбоотой зардлыг авч үзэх. /2015 оны санхүүгийн аудитаар нарийвчилсан горим гүйцэтгэсэн. 2016 оны аудитаар хойшлуулсан./

14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 6,0 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба үүнээс 6,0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн шууд захирагчийн төсвийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 10 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээрээс 1 зөвлөмж нь гаднын хүчин зүйлсээс шалтгаалан биелэгдээгүй ба зөвлөмжийн хэрэгжилт 90.0 хувьтай байна.

16. Зөрчилгүй санал дүгнэлт

Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна..

Аудитлагдсан санхүүгийн тайлан хуудас, хавсралтууд хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛ ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖИЙН ТӨСВИЙН 2016 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах
хаягаар харилцана уу:**

Үндэсний аудитын газар:

1.САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор:
Ц.Наранчимэг
Утас:

2.Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512

“Нью Эстимэйтор Аудит” ХХК:

1.Захирал Ж.Үхэртар
Утас: 99117097

2.Ахлах аудитор Д.Баяраа
Утас: 99359981

Хаяг: УБ хот ЧД, Ж.Самбуу-22
“Зоос гоёл” №213

Аудитынтайлан

Асуудал 1: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын
баримт бичгийн талаар**3**

Асуудал 2: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу
зарцуулах талаар **4**

Асуудал 3: Хууль, дүрэм, журмын хэрэгжилтийн
талаар**5**

Менежментийн захидал

“Нью Эстимэйтор Аудит” ХХК нь аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ҮАГ-ын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

“Нью Эстимэйтор Аудит” ХХК энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу ажлаа хийж гүйцэтгэлээ. Аудитын явцад шаардлагатай баримт материалыг цаг хугацаандаа гаргаж өгч, шаардлагатай мэдээллээр биднийг хангаж байсныг сайшаан тэмдэглэж байна.

Та бүхэн энэхүү менежментийн захидалтай уншиж танилцан бидэнд хариугаа ирүүлнэ үү. Танай хариутай танилцан санхүүгийн тайлагналын талаарх ойлголтоо баталгаажуулсны дараа бид аудитын дүгнэлтээ хүргүүлэх болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн удирдлага болон ажилтнуудад талархал илэрхийлье.

Ажиглалт:

Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/218 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөрийн салбарын "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4 дүгээр бүлгийн 4.3 дахь Бараа, материалын бүртгэлийн 4.3.4-т "Нэг жилээс илүү 3 жилээс бага ашиглалтын хугацаатай хөрөнгийг Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс хэмээн хүлээн зөвшөөрч бараа материалын дансны бүлэгт Хангамжийн материал гэсэн хэсэгт бүртгэж болно" -гэж заасан нь дараах стандарт, заавар, журамтай нийцэхгүй байна. Үүнд:

- Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт /УСНББОУС 17/ "Үндсэн хөрөнгө"-ийн 17.3-т "Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм"-гэж заасан байна.
- Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын НББ-ийн дансны заавар"-ын 4.29-д "Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнэ, элэгдэл шимтгэлийн хэмжээг тодорхойлох, дахин үнэлгээ зэрэг НББ-ийг УСНББОУС17 "Үндсэн хөрөнгө"-ийг дагаж мөрдөнө"-гэж
- Мөн тушаалын 4.15-д "Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө."- гэсэн;
- УСНББОУС 12 "Бараа, материал"-ын 12-т Улсын секторын бараа материалд дараах зүйлс багтана- гэсний дагуу 12(г)-д " Үндсэн Хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн стандартад авч үзсэнээс бусад барилга байгууламж болон тоног төхөөрөмжид ашиглах зорилготой нөөц, сэлбэг" гэж

тус тус хүлээн зөвшөөрөхөөр заасан байдаг байна.

Эрсдэл:

НББ-ийн бодлогын баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэж, толилуулахын тулд бүртгэл хөтлөлтөд ашиглах бүртгэлийн суурийг тодорхойлсон, нийтлэг мөрдөх хууль, стандарт, дүрэм, журамд нийцсэн заавар аргачлалын дагуу бүртгэл хөтлөх практик үйл ажиллагааг тодорхойлсон удирдамж тул санхүүгийн тайлан, толилуулгыг буруу гаргах эрсдэлтэй.

Зөвлөмж:

Байгууллагад Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яаманд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг УСНББОУС болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журамтай нийцүүлж өгөх талаар асуудлыг тавьж шийдвэрлүүлэх зөвлөмжийг өгөх.

Үйлчлүүлэгчийн хариу:

Илэрсэн алдааг асуудлын бүртгэлээр танилцуулан баталгаажуулсан болно.

2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 1/21 тоот албан бичгээр зөвшөөрсөн тухай хариуг авсан..

Ажиглалт:

Урсгал зардалд батлагдсан төсвөөр хичээл, үйлдвэрлэлийн дадлагатай холбогдуулан 6071,9 мянган төгрөгийн ном, оёдлын машин гэсэн үндсэн хөрөнгийг худалдан авсан нь дараахь хууль, журмын заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"-гэсэн;
- Сангийн сайдын баталсан 2013 оны 73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн журам"-ын 8 дугаар зүйлийн 8.1-д "Төсвийн байгууллага нь олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулахаас өөр бусад хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно."-гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Эрсдэл:

Урсгал зардалд батлагдсан төсвөөс үндсэнхөрөнгө хөрөнгө бэлтгэхгүй байх. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах талаар тус тус зөвлөмж өгөх

Зөвлөмж:

Урсгал зардалд батлагдсан төсвөөс үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах талаар тус тус зөвлөмж өгөх.

Үйлчлүүлэгчийн хариу:

Илэрсэн алдааг асуудлын бүртгэлээр танилцуулан баталгаажуулсан болно. 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 1/21 тоот албан бичгээр зөвшөөрсөн тухай хариуг авсан.

2016 ОНЫ АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Аудитласан-Эхний үлдэгдэл	Аудитласан- Эцсийн үлдэгдэл	С"д"д	С"д"д
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ	3	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Кассад байгаа бэлэн мөнгө		0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Төгрөг ЖМС							
Банкинд байгаа бэлэн мөнгө		0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Төгрөг							
Замд яваа мөнгөн хөрөнгө							
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Төгрөг							
АВЛАГА	4	2,924,769.42	0.00	0.00	0.00	0.00	0.00
Ажиллагчидтай холбогдсон							
Бусад авлага		2,924,769.42	0.00	0.00	0.00	0.00	0.00
Байгууллагаас авах авлага		2,924,769.42					
Хувь хүмүүсээс авах авлага							
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР		0.00	4,800,000.00	4,800,000.00	4,800,000.00	0.00	0.00
Урьдчилгаа тооцоо							
Урьдчилж гарсан зардал			4,800,000.00	4,800,000.00	4,800,000.00		
БАРАА МАТЕРИАЛ	5	325,957,535.48	192,931,655.19	192,931,655.19	192,931,655.19	0.00	0.00
Түүхий эд материал							
Тусгай зориулалтын материал		272,242,876.53	142,959,842.00	142,959,842.00	142,959,842.00		
Бичиг хэргийн материал		2,822,834.80	929,800.00	929,800.00	929,800.00		
Түлш, шатах тослох материал			60,000.00	60,000.00	60,000.00		
Бусад хангамжийн материал		60,000.00	354,000.00	354,000.00	354,000.00		
Мал, амьтад							
Барилга засварын материал		2,132,026.00	802,870.00	802,870.00	802,870.00		
Сэлбэг хэрэгсэл		278,540.00	278,540.00	278,540.00	278,540.00		
БҮТЭЭ		11,478,074.53	28,371,671.53	28,371,671.53	28,371,671.53		
Бэлэн бүтээгдэхүүн		858,769.96	28,600.00	28,600.00	28,600.00		
Аж ахуйн материал		35,374,511.66	19,146,331.66	19,146,331.66	19,146,331.66		
Эм, боох материал		709,902.00					
НӨӨЦИЙН БАРАА		0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Бусад нөөц							
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		328,882,304.90	197,731,655.19	197,731,655.19	197,731,655.19	0.00	0.00
ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГӨ							
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6						
Биет хөрөнгө		2,776,328,119.70	3,444,618,130.88	3,444,618,130.88	3,444,618,130.88	0.00	0.00
Барилга, байгууламж, орон сууц		3,561,931,714.00	3,561,931,714.00	3,561,931,714.00	3,561,931,714.00		
Хуримтлагдсан элэгдэл		(2,851,721,055.56)	(2,911,086,584.12)	(2,911,086,584.12)	(2,911,086,584.12)		
Авто- тээврийн хэрэгсэл		89,880,000.00	126,730,000.00	126,730,000.00	126,730,000.00		
Хуримтлагдсан элэгдэл		(27,580,000.00)	(51,433,777.87)	(51,433,777.87)	(51,433,777.87)		
Машин, тоног төхөөрөмж		2,403,882,912.81	3,694,031,184.81	3,694,031,184.81	3,694,031,184.81		
Хуримтлагдсан элэгдэл		(925,921,038.58)	(1,547,105,759.62)	(1,547,105,759.62)	(1,547,105,759.62)		
Тавилга, аж ахуйн эд хогшил		534,161,229.39	670,122,044.39	670,122,044.39	670,122,044.39		
Хуримтлагдсан элэгдэл		(238,157,497.03)	(324,790,529.75)	(324,790,529.75)	(324,790,529.75)		
Номын фонд		176,277,944.49	181,266,896.49	181,266,896.49	181,266,896.49		
Хуримтлагдсан элэгдэл							
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс							
Бусад үндсэн хөрөнгө		114,726,332.80	116,526,332.80	116,526,332.80	116,526,332.80		
Хуримтлагдсан элэгдэл		(61,152,422.62)	(71,573,390.25)	(71,573,390.25)	(71,573,390.25)		
Нийтийн эзэмшлийн талбай							
Хуримтлагдсан элэгдэл							
Дусаагүй барилга, байгууламж							
Биет бус хөрөнгө		31,118,006.90	36,077,900.22	36,077,900.22	36,077,900.22	0.00	0.00
Программ хангамж		59,150,920.55	80,883,160.55	80,883,160.55	80,883,160.55		
Хасалдуулга		(28,032,913.65)	(44,805,260.33)	(44,805,260.33)	(44,805,260.33)		
Бусад биет бус хөрөнгө							
Хасалдуулга							

ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,807,446,126.60	3,480,696,031.10	3,480,696,031.10	3,480,696,031.10	0.00	0.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		3,136,328,431.50	3,678,427,686.29	3,678,427,686.29	3,678,427,686.29	0.00	0.00
ӨР ТӨЛБӨР							
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР							
Богино хугацаат өр төлбөр							
Өглөг		3,762,950.00	13,254,522.48	13,254,522.48	13,254,522.48	0.00	0.00
Ажиллагчидтай холбогдсон тооцоо							
Бараа үйлчилгээний зардлын тооцоо татаас, санхүүжилт, шилжүүлгийн тооцоо							
НДШ-ийн өглөг			2,744,542.48	2,744,542.48	2,744,542.48		
ХАОАТ-өглөг			10,255,940.00	10,255,940.00	10,255,940.00		
Бусад өглөг			254,040.00	254,040.00	254,040.00		
Байгууллагад төлөх өглөг		3,762,950.00					
Хувь хүмүүст төлөх өглөг							
Урьдчилж орсон орлого		0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Урьдчилгаа - Төсвийн татаас							
Бусад урьдчилж орсон орлого							
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	7	3,762,950.00	13,254,522.48	13,254,522.48	13,254,522.48	0.00	0.00
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР							
Урт хугацаат зээл		0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Төгрөгөөр							
Гадаад валют							
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН	8	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		3,762,950.00	13,254,522.48	13,254,522.48	13,254,522.48	0.00	0.00
Засгийн газрын хувь оролцоо		3,132,565,481.50	3,665,173,163.81	3,665,173,163.81	3,665,173,163.81	0.00	0.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН		3,132,565,481.50	3,665,173,163.81	3,665,173,163.81	3,665,173,163.81	0.00	0.00
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН		3,136,328,431.50	3,678,427,686.29	3,678,427,686.29	3,678,427,686.29	0.00	0.00
		0.00	0.00	0.00	0.00		

БАЙГУУЛЛАГЫН НЭР: ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

2016 ОНЫ АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он	Аудитласан	
1	2	3	4	4	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	1				
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО					
Улсын төсвөөс		2,518,073,130.95	1,922,390,750.00	1,922,390,750.00	0.00
Урсгал		1,857,539,240.00	1,736,652,500.00	1,736,652,500.00	0.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгасан		620,598,441.00	185,678,250.00	185,678,250.00	0.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны дагуу		27,330,650.00	60,000.00	60,000.00	0.00
Төсвийн урамшуулал		12,604,799.95			0.00
Тусламжийн орлого		0.00	0.00	0.00	0.00
Хөрөнгийн орлого					0.00
					0.00
Урьд оны өр төлбөр					0.00
Төслийн орлого					0.00
Залруулга					0.00
Бараа, үйлчилгээний орлого		363,341,745.06	2,089,929,863.25	2,089,929,863.25	0.00
Үндсэн үйл ажиллагааны орлого		299,337,260.00	329,052,400.00	329,052,400.00	0.00
Туслах үйл ажиллагааны орлого		32,430,060.00	47,732,570.00	47,732,570.00	0.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		31,574,425.06	1,708,160,081.25	1,708,160,081.25	0.00
Бусад орлого			4,984,812.00	4,984,812.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ҮР ДҮН (1)		2,881,414,876.01	4,012,320,613.25	4,012,320,613.25	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ					0.00
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	2	1,647,728,488.69	1,500,978,453.90	1,500,978,453.90	0.00
Үндсэн болон нэмэгдэл цалин		1,490,046,898.00	1,352,629,120.00	1,352,629,120.00	0.00
Үндсэн цалин		1,008,915,242.00	1,277,029,120.00	1,277,029,120.00	0.00
Унааны хөнгөлөлт			75,600,000.00	75,600,000.00	0.00
Урамшуулал		481,131,656.00			0.00
Нийгмийн хамгааллын шимтгэл		157,681,590.69	148,349,333.90	148,349,333.90	0.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл		157,681,590.69	148,349,333.90	148,349,333.90	0.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж					0.00
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ		1,671,802,508.75	1,979,801,477.04	1,979,801,477.04	0.00
Тогтмол зардал		74,984,227.90	99,445,792.77	99,445,792.77	0.00
Гэрэл цахилгаан		37,738,233.36	49,206,336.21	49,206,336.21	0.00
Тулш, халаалт		27,022,719.90	29,379,741.40	29,379,741.40	0.00
Цэвэр, бохир ус		10,223,274.64	20,859,715.16	20,859,715.16	0.00
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал		1,596,818,280.85	1,880,355,684.27	1,880,355,684.27	0.00
Хоол		93,632,855.00	70,001,225.00	70,001,225.00	0.00
Эм, вакцин		409,600.00	835,000.00	835,000.00	0.00
Бусад бараа үйлчилгээний зардал		1,502,775,825.85	1,809,519,459.27	1,809,519,459.27	0.00
Бичиг хэргийн материал		13,863,387.98	3,306,034.00	3,306,034.00	0.00
Тээвэр, шатахуун		4,722,900.00	4,180,000.00	4,180,000.00	0.00
Шуудан, харилцаа холбоо		8,647,452.80	6,005,666.05	6,005,666.05	0.00
Дотоод албан томилолт		2,015,500.00	1,600,080.00	1,600,080.00	0.00
Гадаад арга хэмжээ					0.00
Ном , хөвлэл захиалах, худалдан авах		3,431,600.00			0.00
Хичээл , үйлдвэрлэлийн дадлага		132,154,182.20	535,106,699.29	535,106,699.29	0.00
Сургалт семинарын зардал					0.00
Тээврийн хэрэгслийн оношлого					0.00
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс			9,635,851.00	9,635,851.00	0.00
Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл		1,439,250.00	290,500.00	290,500.00	0.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл			237,200.00	237,200.00	0.00
Аж ахуйн материал худалдан авах зардал					0.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ			146,046,497.00	146,046,497.00	0.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр					0.00
Аудитын төлбөр		3,000,000.00	3,000,000.00	3,000,000.00	0.00
Урсгал засвар		194,382,794.68	6,155,796.00	6,155,796.00	0.00

Банкны үйлчилгээний хураамж					0.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ		862,800.00			0.00
Тээврийн хэрэгслийн татвар		1,164,630.00	156,300.00	156,300.00	0.00
Тээврийн хэрэгслийн даатгал			981,130.00	981,130.00	0.00
Хог хаягдал устгах, цэвэрлэх			2,550,000.00	2,550,000.00	0.00
Шангал урамшуулал					0.00
Газрын төлбөр					0.00
Эрүүл хүүхэд аян					0.00
					0.00
Хөтөлбөр арга хэмжээ					0.00
Урьд оны төсвийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн					0.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		8,823,359.95			0.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		477,156,541.00	278,901,230.00	278,901,230.00	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		71,620,252.00	7,450,200.00	7,450,200.00	
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		444,771,384.88	802,876,207.75	802,876,207.75	0.00
Сангийн яам төвлөрүүлэх		134,719,790.36	1,040,068.18	1,040,068.18	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (2)		3,319,530,997.44	3,480,779,930.94	3,480,779,930.94	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)		-438,116,121.43	531,540,682.31	531,540,682.31	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ОРЛОГО					0.00
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз / бодит/					0.00
Үндсэн хөрөнгө худалдсаны олз					0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ОРЛОГЫН ДҮН (4)		0.00	0.00	0.00	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ЗАРДАЛ					0.00
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз / бодит/					0.00
Бараа материал акталсан					0.00
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз					0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ЗАРДЛЫН ДҮН (5)		0.00	0.00	0.00	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		-438,116,121.43	531,540,682.31	531,540,682.31	0.00

БАЙГУУЛЛАГЫН НЭР: ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

2016 ОНЫ АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он	Аудитласан	Зөрүү
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО					
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1				
		2,518,073,130.95	1,924,170,750.00	1,924,170,750.00	
Улсын төсвөөс		2,518,073,130.95	1,924,170,750.00	1,924,170,750.00	
Урсгал		1,857,539,240.00	1,736,652,500.00	1,736,652,500.00	
Нэмэлт санхүүжилтийн орлого					
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгасан		620,598,441.00	187,458,250.00	187,458,250.00	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны дагуу		27,330,650.00	60,000.00	60,000.00	
Төсвийн урамшуулал		12,604,799.95			
Эрүүл хүүхэд аяны санхүүжилт					
Орон нутгийн төсвөөс		0.00	0.00	0.00	
Орон нутгийн төсвөөс					
Бараа, үйлчилгээний орлого		331,767,320.00	378,748,403.00	378,748,403.00	0.00
Бусад орлого			1,963,433.00	1,963,433.00	
Үндсэн үйл ажиллагааны орлого		299,337,260.00	329,052,400.00	329,052,400.00	
Туслах үйл ажиллагааны орлого		32,430,060.00	47,732,570.00	47,732,570.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)		2,849,840,450.95	2,302,919,153.00	2,302,919,153.00	0.00
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	2	1,648,858,910.64	1,483,324,783.00	1,483,324,783.00	0.00
Үндсэн болон нэмэгдэл цалин		1,490,046,898.00	1,335,313,963.00	1,335,313,963.00	0.00
Үндсэн цалин		1,490,046,898.00	1,259,713,963.00	1,259,713,963.00	
Унааа, хоолны хөнгөлөлт			75,600,000.00	75,600,000.00	
Цалингийн тусгай нэмэгдэл					
Нийгмийн хамгааллын шимтгэл		158,812,012.64	148,010,820.00	148,010,820.00	0.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл		158,812,012.64	148,010,820.00	148,010,820.00	
Эрүүл мэндийн даатгалын хураамж					
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ		1,161,491,096.52	802,843,470.00	802,843,470.00	0.00
Тогтмол зардал		74,984,227.90	99,445,792.77	99,445,792.77	0.00
Гэрэл цахилгаан		37,738,233.36	49,206,336.21	49,206,336.21	
Түлш, халаалт		27,022,719.90	29,379,741.40	29,379,741.40	
Цэвэр, бохир ус		10,223,274.64	20,859,715.16	20,859,715.16	
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал		94,752,407.00	71,226,625.00	71,226,625.00	0.00
Хоол		93,632,855.00	70,001,225.00	70,001,225.00	
Эм, вакцин		1,119,552.00	1,225,400.00	1,225,400.00	
Бусад бараа үйлчилгээний зардал		991,754,461.62	632,171,052.23	632,171,052.23	0.00
Бичиг хэргийн материал		2,542,649.00	2,822,520.00	2,822,520.00	
Тээвэр, шатахуун		4,722,900.00	3,990,000.00	3,990,000.00	
Шуудан, харилцаа холбоо		7,580,452.80	6,005,666.05	6,005,666.05	
Дотоод албан томилолт		2,015,500.00	1,600,080.00	1,600,080.00	
Гадаад албан томилолт					
Ном , хэвлэл захиалах, худалдан авах		3,431,600.00			
Мэдээлэл суртчилгааны зардал					
Сургалт семинарын зардал					
БҮТЭЗ			4,212,837.00	4,212,837.00	
Багаж техник хэрэгсэл		2,499,480.00	1,756,000.00	1,756,000.00	
Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл		5,129,040.00	3,912,500.00	3,912,500.00	
Төлбөр хураамж, жижиг татварууд					
Мэдээлэл технологийн үйлчилгээ		150,000.00			
Тээврийн хэрэгслийн татвар		1,164,630.00	156,300.00	156,300.00	
Аудитын төлбөр		3,000,000.00	3,000,000.00	3,000,000.00	
Урсгал засвар		164,154,436.20	4,990,800.00	4,990,800.00	
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал					
Газрын төлбөр					
Тээврийн хэрэгслийн татвар					
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл			3,165,700.00	3,165,700.00	
Тээврийн хэрэгслийн даатгал					
Даатгалын үйлчилгээ			981,130.00	981,130.00	
Хичээл дадлагын материалын зардал		101,253,830.31	160,089,524.00	160,089,524.00	

Хог хаягдал устгах, цэвэрлэх			2,050,000.00	2,050,000.00	
Эрүүл хүүхэд аян					
Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ			146,046,497.00	146,046,497.00	
Сангийн яам төвлөрүүлэх		136,499,790.36	1,040,068.18	1,040,068.18	
Төрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил үйлчилгээ					
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал		477,156,541.00	278,901,230.00	278,901,230.00	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		71,630,252.00	7,450,200.00	7,450,200.00	
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		8,823,359.95			
Шагнал урамшуулал					
2011 оны жилийн эцсийн үлдэгдэл					
Төвлөрүүлэх шилжүүлэг					
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)					
		2,810,350,007.16	2,286,168,253.00	2,286,168,253.00	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3=1-2)		39,490,443.79	16,750,900.00	16,750,900.00	0.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ					
Хөрөнгийн орлого					
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого / Үндсэн хөрөнгө авахад олгосон санхүүжилт/					
Бусад хөрөнгийн борлуулалтын орлого					
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		0.00	0.00	0.00	
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал					
Хөрөнгийн бусад зардал					
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (5)		0.00	0.00	0.00	
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(6=4-5)		0.00	0.00	0.00	
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ					
Авсан зээл					
Төлсөн зээл					
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (8)		0.00	0.00	0.00	0.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (9=7+8)		39,490,443.79	16,750,900.00	16,750,900.00	0.00
Мөнгө ба түүтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				0.00	
Мөнгө ба түүтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			0.00	0.00	

0

0

0

39,490,443.79

16,750,900.00

16,750,900.00

0

СТ-4А
БАЙГУУЛЛАГЫН НЭР: ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

2016 ОНЫ АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭГТ					Аудитлагсан				Зөрүү			
	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлэгдэж нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлэгдэж нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Засгийн газрын орүүлсан капитал	Дахин үнэлэгдэж нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2015.01.01-ний үлдэгдэл	2,525,269,411.59	277,113,100.00	330,182,969.91	3,132,565,481.50	2,525,269,411.59	277,113,100.00	330,182,969.91	3,132,565,481.50	0.00	0.00	0.00	0.00
НЭБ-ийн бодлогын өөрчлөлт				0.00				0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин нэвчлэгдсэн үлдэгдэл				0.00				0.00	0.00	0.00	0.00	0.00
Тогдсан хөрөнгийн дахин үнэлэгдэж өсөлт				0.00				0.00	0.00	0.00	0.00	0.00
Тогдсан хөрөнгийн дахин үнэлэгдэж бууралт				0.00				0.00	0.00	0.00	0.00	0.00
Оролцлын тайлангад хүтээх зөвшөөрөгүй осл, гэрл				0.00				0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлангад үеийн үр дүн				0.00				0.00	0.00	0.00	0.00	0.00
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,525,269,411.59	277,113,100.00	330,182,969.91	3,132,565,481.50	2,525,269,411.59	277,113,100.00	330,182,969.91	3,132,565,481.50	0.00	0.00	0.00	0.00
НЭБ-ийн бодлогын өөрчлөлт			1,067,000.00	1,067,000.00			1,067,000.00	1,067,000.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин нэвчлэгдсэн үлдэгдэл				0.00				0.00	0.00	0.00	0.00	0.00
Тогдсан хөрөнгийн дахин үнэлэгдэж өсөлт				0.00				0.00	0.00	0.00	0.00	0.00
Тогдсан хөрөнгийн дахин үнэлэгдэж бууралт				0.00				0.00	0.00	0.00	0.00	0.00
Тогдсан хөрөнгийн нэмэгдэл /дараа гэрэллэс/				0.00				0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчлөх үеийн үр дүн				0.00				0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлангад үеийн үр дүн			531,540,682.31	531,540,682.31			531,540,682.31	531,540,682.31	0.00	0.00	0.00	0.00
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,525,269,411.59	277,113,100.00	862,796,652.22	3,665,173,163.81	2,525,269,411.59	277,113,100.00	862,796,652.22	3,665,173,163.81	0.00	0.00	0.00	0.00

БАЙГУУЛЛАГЫН НЭР: ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

2016 оны Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

	Эдийн засгийн ангилал Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	1	2	3	4	5
	Эхний үлдэгдэл		-		
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,140,270,500.00	2,300,148,651.82	(152,367,815.61)	107.5
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,140,270,500.00	2,300,148,651.82	(152,367,815.61)	107.5
III	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,140,270,500.00	2,300,148,651.82	(152,367,815.61)	107.5
	Бараа, үйлчилгээний зардал	1,915,815,500.00	2,013,797,221.82	(90,471,385.61)	105.1
	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,347,794,100.00	1,335,313,963.00	12,480,137.00	99.1
	Үндсэн цалин	1,265,594,100.00	1,259,713,963.00	5,880,137.00	99.5
	Үр дүнгийн урамшуулал				
	Унаа болон бусад нэмэгдэл	82,200,000.00	75,600,000.00	6,600,000.00	92.0
	Нийтийн хамгаалалын шимтгэл	148,257,400.00	148,010,820.00	246,580.00	99.8
	Тэтгэврийн даатгал	148,257,400.00	148,010,820.00	246,580.00	99.8
	Тэтгэмжийн даатгал	-	-	-	
	ҮОМШ өвчний даатгал			-	
	Ажилгүйдлийн даатгал			-	
	Байгууллага төлөх ЭМД-ын хураамж			-	
	Бараа, үйлчилгээний урсгал зардал	419,764,000.00	530,472,438.82	(103,198,102.61)	126.4
	Гэрэл цахилгааны зардал	41,696,000.00	49,206,336.21	(7,510,336.21)	118.0
	Түлш, халаалтын зардал	44,747,700.00	29,379,741.40	15,367,958.60	65.7
	Цэвэр, бохир усны зардал	17,000,000.00	20,859,715.16	(3,859,715.16)	122.7
	Хоол	68,195,000.00	70,001,225.00	(1,806,225.00)	102.6
	Эм	1,000,000.00	1,225,400.00	(225,400.00)	122.5
	Бичиг хэргийн материал	5,412,200.00	2,694,620.00	2,717,580.00	49.8
	Тээвэр, шатахууны зардал	4,065,000.00	3,990,000.00	75,000.00	98.2
	Шуудан холбооны зардал	5,036,900.00	6,005,666.05	(968,766.05)	119.2
	Дотоод томилолтын зардал	2,188,700.00	1,600,080.00	588,620.00	73.1
	Ном, хэвлэлийн зардал			-	
	Мэдээлэл сурталчилгаа			-	
	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,130,000.00	2,050,000.00	(920,000.00)	181.4
	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	3,165,200.00	3,958,004.00	(792,804.00)	125.0
	Жижиг эд хогшил худалдан авах зардал /БҮТЭЗ			-	
	Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	4,144,000.00	3,912,500.00	231,500.00	94.4
	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	5,487,400.00	3,165,700.00	2,321,700.00	57.7
	Багаж техник хэрэгсэл	1,074,000.00	13,335,900.00	(12,261,900.00)	1241.7
	Урсгал засварын зардал	4,905,200.00	4,990,800.00	(85,600.00)	101.7
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	50,000,000.00	146,046,497.00	(96,046,497.00)	292.1
	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00		500,000.00	0.0
	Даатгалын үйлчилгээ	3,600,000.00	981,130.00	2,618,870.00	
	Аудитын төлбөр	3,000,000.00	3,000,000.00	-	
	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	153,416,700.00	164,069,124.00	(10,652,424.00)	
	Буцаан төвлөрүүлсэн /2016 оны эцсийн үлдэгдэл/			-	
	Татаас ба урсгал шилжүүлэг	224,455,000.00	286,351,430.00	(61,896,430.00)	127.6
	Өрх гэрт олгох шилжүүлэг	224,455,000.00	286,351,430.00	(61,896,430.00)	127.6
	Нийгмийн халамжийн	224,455,000.00	286,351,430.00	(61,896,430.00)	127.6
	Өндөр настан ахмад дайчдад	7,450,000.00	7,450,200.00	(200.00)	
	Нэг удаагийн тэтгэмж	217,005,000.00	278,901,230.00	(61,896,230.00)	128.5
IV	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	
	Хөрөнгө оруулалтын зардал	-	-	-	
	1. Дотоод хөрөнгө оруулалт	-	-	-	
	Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр санхүүжих				
	хөрөнгө оруулалт				
	2. Улсын нөөцийн эх үүсвэр нэмэгдүүлэх	-	-	-	0.0
	Шатахууны нөөц				
V	Эрээж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл				
VI	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР:	2,140,270,800.00	2,300,148,651.82	(159,877,851.82)	107.5
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	310,000,000.00	328,072,331.82	(18,072,331.82)	105.8
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	92,000,000.00	47,732,570.00	44,267,430.00	
	Бусад орлого		233,000.00		
	Дээд шатнаас олгосон		187,458,250.00		
	Төсвөөс санхүүжих	1,738,270,800.00	1,736,652,500.00	1,618,300.00	99.9
	Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл		0.00		
	Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт				

	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
	АЖИЛЛАГСАД БҮГД	138	138		
	Удирдах ажилтан	2	2		
	Гүйцэтгэх ажилтан	127	127		
	Үйлчлэх ажилтан	9	9		
	Гэрээт ажилтан				